



## НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 5/06

Улаанбаатар хот

Г

Урамшуулалт олгох тухай

Г

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Санхүү, эдийн засгийн сайдын 2006 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 192 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/314 дүгээр захирамжаар батлагдсан тус газрын дүрмийн 4.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн хуульд нийцүүлж, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг сайжруулж, 2013 оны байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайлан, салбарын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тооцоог хугацаанд нь гаргаж, Нийслэлийн Аудитын байгууллагаас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар санхүү, төсвийн сахилга батыг ханган биелүүлж “Зөрчилгүй санал дүгнэлт” стандарт түвшний үнэлгээ авсан тул тус газрын нягтлан бодогч О.Эрдэнэцэцэгийг 2 сарын, нярав Г.Цэрэннадмидыг 1 сарын үндсэн цалингаар урамшуулсугай.

2. Урамшуулалд шаардагдах 1.549.963 /нэг сая таван зуун дөчин есөн мянга есөн зуун жаран гурав/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг нягтлан бодогч О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.ГАНБОЛД



1150500181